



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/574

Арвайхээр сум

Шуурхай бүлэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хужирт сумын Өвөр модот нэгдүгээр баг, Уужим хоёрдугаар баг, Дулаан зургаадугаар баг, Бүрд сумын Ар жаргалант нэгдүгээр багийн нутаг дэвсгэрт орсон их хэмжээний цасны улмаас өвөлжилт хүндэрч, зам даваа хаах, түлээ нүүрс, өвс, тэжээл татан авах, отор нүүдэл хийхэд зам давааг нээх зорилгоор 14 хоногийн томилолтоор ажиллах шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан 4,287,360 (дөрвөн сая хоёр зуун наян долоон мянга гурван зуун жар) төгрөгийн зардлыг аймгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0127

Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр
сарын 1-ны өдрийн 1 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ШУУРХАЙ БҮЛГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1 дүгээр бүлгийн Ахлагч: П.Мөнхдалай (Эрэн хайх, аврах бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, ахлах дэслэгч)

Гишүүд:

Б.Баярсайхан (Хужирт сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, дэслэгч)

Б.Цэрэнбалдан (Аврагч, усчин ахлагч)

У.Баатархүү (Аврагч, усчин ахлах ахлагч)

Д.Батхуяг (Аврагч, холбоочин жолооч ахлах ахлагч)

Х.Ням-Очир (Аврагч, холбоочин жолооч ахлах ахлагч)

2 дугаар бүлгийн ахлагч: Б.Балжинням (Хуягт техникийн инженер, ахлах дэслэгч)


Гишүүд:

Б.Нармандах (Засварын тасгийн захирагч, ахлах ахлагч)

Б.Хангарьд (Тээврийн салааны жолооч, ахлагч)

-оОо-

Аймгийн Засаг даргын 2024 оны 2 дүгээр сарын 28-ны өдрийн 1754 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжээ (л)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
Бүрд суманд зарцуулах түлшний тооцоо					
1	Түлш	441	4060	1,790,460	Туулах чадвар сайтай ЗИЛ-131 машин Бүрд суманд ирж ажиллахад 800 км явах бөгөөд (100 км-т 80 л шатахуунаар явахаар тооцов)
Хужирт суманд зарцуулах түлшний тооцоо					
2	Түлш	615	4060	2,496,900	Туулах чадвар сайтай машин Хужирт суманд ирж ажиллахад 1070 км явах бөгөөд (100 км-т 80 л шатахуунаар явахаар тооцов)
Нийт үнэ					4,287,360